

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
1/9 дугаар тогтоолын Дөрөвдүгээр хавсралт

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦООГ ГҮЙЦЭТГЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар "Монголын хөрөнгийн бирж" ХК (цаашид "Бирж" гэх)-ийн уул уурхайн бүтээгдэхүүний спот, форвард гэрээний арилжааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, зах зээлд оролцогчдын арилжааны үйл ажиллагаатай холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.
- 1.2. Уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан фьючерс, опцион санхүүгийн хэрэгслийн арилжааг Биржийн "Арилжааны журам"-аар, төлбөрийн болон тооцооны үйл ажиллагааг "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-үүсмэл санхүүгийн хэрэгслийн клирингийн журмаар зохицуулна.
- 1.3. Биржийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаатай холбоотой үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/ болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ
- 1.4. Энэхүү журмыг Бирж, гишүүн брокер болон түүний харилцагчид, итгэмжлэгдсэн агуулах, терминал болон уул уурхайн бүтээгдэхүүний зохицуулалттай зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.

ХОЁР. ЖУРМЫН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1. "Спот гэрээ" гэж Хорооны "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр, тооцооны ерөнхий журам"-ын 2.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэрээг;
 - 2.1.2. "Форвард гэрээ" гэж талууд тодорхой тоо, хэмжээ бүхий бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд, арилжааны үр дүнд тогтсон үнэ, нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээг;
 - 2.1.3. "Гэрээ" гэж спот болон форвард гэрээг;
 - 2.1.4. "Форвард гэрээний дуусгавар болох хугацаа" гэж тухайн форвард гэрээнд заасны дагуу хүргэлт хийгдэх хугацааг;
 - 2.1.5. "Дэнчин" гэж Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 4.1.5-д заасныг;
 - 2.1.6. "Харилцагч" гэж уул уурхайн бүтээгдэхүүн худалдах эсхүл худалдан авахаар Бирж эсхүл гишүүн брокертой гэрээ байгуулсан хуулийн этгээдийг.
 - 2.1.7. "Агуулахын баримт" гэж Биржээс баталсан уул уурхайн

бүтээгдэхүүнийн гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан журмын хавсралт баримтыг.

ГУРАВ. АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Худалдах захиалга хүлээн авах

- 3.1. Уул уурхайн бүтээгдэхүүн худалдагч нь ашигт малтмалын ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй эсхүл ашигт малтмалыг боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээд байх бөгөөд Биржид худалдагчаар бүртгүүлж, гэрээ байгуулахдаа дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. Худалдагч этгээдийн сүүлийн 1 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан;
 - 3.1.2. Компанийн үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөний танилцуулга;
 - 3.1.3. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө болон өмнөх жилийн уулын ажлын тайлан /жич: боловсруулах үйлдвэрийн хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ/;
 - 3.1.4. Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад.
- 3.2. Бирж нь худалдагчаар бүртгүүлэх этгээдийн баримт материалыг ажлын 5 хоногийн дотор хянаж, гэрээ байгуулна.
- 3.3. Арилжааны гэрээний үүрэг хариуцлагыг тухайн арилжаанд зуучилсан брокер хариуцах ба зуучлагчгүй оролцох тохиолдолд гэрээний үүрэг, хариуцлагыг худалдагч, худалдан авагч этгээд хариуцна.
- 3.4. Худалдагч эсхүл түүнтэй зуучлалын гэрээ байгуулсан брокер нь Биржээр худалдах бүтээгдэхүүний захиалгыг дараах бүрдүүлбэрийн хамт арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-гоос доошгүй өдрийн өмнө Биржид ирүүлнэ. Үүнд:
 - 3.4.1. Энэхүү журмын Хавсралт 1-д тусгагдсан "Уул уурхайн бүтээгдэхүүн арилжих захиалга";
 - 3.4.2. Спот гэрээний хувьд агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн шинжилгээний лабораторын дүгнэлт;
 - 3.4.3. Энэхүү журмын Хавсралт 2-т тусгагдсан бүртгэх үйлчилгээний хөлс төлсөн баримт.
- 3.5. Спот гэрээгээр арилжигдах захиалгад арилжаалах бүтээгдэхүүн, арилжигдах багц (лот)-аар илэрхийлсэн тоо, хэмжээ, дуудах доод үнэ, үнийг илэрхийлэх валют, үнийн хамгийн бага өөрчлөлт, арилжааны цаг, хүргэлт хийх хугацаа, нөхцөл, гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний чанар, дэнчингийн хэмжээ, бүтээгдэхүүн нийлүүлэх цэг, тээвэрлэлтийн төрөл зэргийг тусгана.
- 3.6. Форвард гэрээгээр арилжигдах захиалгад арилжаалах бүтээгдэхүүн, арилжигдах багц (лот)-аар илэрхийлсэн тоо, хэмжээ, дуудах доод үнэ, үнийг илэрхийлэх валют, үнийн хамгийн бага өөрчлөлт, гэрээ дуусгавар болох хугацаа, арилжааны цаг, хүргэлт хийх хугацаа, нөхцөл, хэсэгчилж хүргэлт хийх тохиолдолд хүргэлтийн хуваарь, гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний чанар, дэнчингийн хэмжээ, бүтээгдэхүүн нийлүүлэх цэг,

- тээвэрлэлтийн төрөл, үнийн тохируулгатай бол тухайн тохируулгын нөхцөл, тооцох аргачлал зэргийг тусгана.
- 3.7. Худалдагч эсхүл брокер нь худалдах захиалгад дурдсан мэдээлэл болон түүний бүрдүүлбэрийг үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөнө.
 - 3.8. Бирж нь худалдах захиалгыг хүлээн авч, ажлын 2 өдрийн дотор бүрдүүлбэрийг шалгана.
 - 3.9. Худалдагч эсхүл брокерийн ирүүлсэн худалдах захиалга нь шаардлага хангасан тохиолдолд Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар бүртгэж, захиалга тус бүрт бүртгэлийн код олгоно.
 - 3.10. Бирж нь энэхүү журмын 3.9-д заасан хугацаанд захиалгатай холбоотой шаардлагатай нэмэлт мэдээллийг худалдагч, хэрэв брокертой бол брокероос тодруулж, гаргуулан авч болно.
 - 3.11. Дараах тохиолдолд Бирж худалдах захиалгыг бүртгэхээс татгалзана. Үүнд:
 - 3.11.1. захиалгын мэдээлэл болон бүрдүүлбэр дутуу;
 - 3.11.2. захиалга, түүний бүрдүүлбэрт байгаа мэдээллийг үнэн зөв мэдүүлээгүй;
 - 3.11.3. холбогдох хууль тогтоомжид заасан бусад.
 - 3.12. Бирж нь энэхүү журмын 3.11-д заасны дагуу захиалгыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай худалд агч эсхүл брокерт цахимаар мэдэгдэнэ.
 - 3.13. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурсан тохиолдолд худалдагчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий хүсэлтийг үндэслэн Бирж нь захиалгын дуудах доод үнэд арилжаа зохион байгуулагдахаас ажлын 1-ээс доошгүй өдрийн өмнө Гүйцэтгэх захирлын тушаалаар өөрчлөлт оруулна.
 - 3.14. Бирж нь дуудах доод үнийг энэ журмын 3.13-д заасны дагуу худалдагчийн хүсэлтийн дагуу өөрчилсөн тухай өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
 - 3.15. Худалдах захиалгад тусгагдсан арилжаа зохион байгуулах он, сар, өдрийг арилжааны төлөвлөгөөтэй уялдуулан Худалдагчтай зөвшилцөж өөрчлөн бүртгэж болно.
 - 3.16. Тухайн бүтээгдэхүүн арилжих захиалгын дагуу арилжаа зохион байгуулагдаж, экспортын гэрээ дуусгавар болсноор арилжааны систем дэх тухайн бүтээгдэхүүнийг бүртгэлээс хасна.

Худалдан авах захиалга бүртгэх

- 3.17. Худалдан авах санал гаргагч нь Биржид бүртгүүлж арилжаанд оролцох ба Биржийн гишүүн брокероор дамжуулан эсхүл өөрөө Биржтэй гэрээ байгуулсны үндсэн дээр бүртгүүлнэ.
- 3.18. Худалдан авах санал гаргагч нь Биржид бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг Монгол эсхүл Англи хэл дээрх баталгаат орчуулгын хамт хүргүүлнэ. Үүнд:
 - 3.18.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - 3.18.2. Харилцагч банкны дансны тодорхойлолт;
 - 3.18.3. Монгол Улсад бүртгэлтэй төлөөлөгчийн газартай бол холбогдох мэдээлэл;
 - 3.18.4. Шаардлагатай гэж үзсэн бусад баримт.

- 3.19. Худалдан авах санал гаргагч эсхүл брокер нь харилцагчийн мэдээллийг Биржийн арилжааны системд бүртгүүлж, харилцагчийн код авах ба тухайн код нь худалдан авах санал гаргагчийг таних дахин давтагдашгүй код байна.
- 3.20. Худалдан авах санал гаргагч эсхүл брокер нь арилжаанд оролцохдоо дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 3.20.1. Биржээс олгосон арилжааны системд хандах эрхээр нэвтэрч арилжаанд оролцох;
- 3.20.2. Өөрийн тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдлыг хангаж арилжаанд оролцох;
- 3.20.3. Арилжааны системд нэвтрэх эрхийг бусдад дамжуулах, шилжүүлэх, нууцлалыг алдагдуулахгүй байх, үүнээс үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 3.20.4. Арилжааны системтэй холбоотой ямар нэг алдаа илэрвэл Биржид яаралтай мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.
- 3.21. Худалдан авагч эсхүл түүний брокер нь арилжааны явцад захиалгын санд оруулах худалдан авах үнийн саналын үнэн зөв, түүнээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.22. Худалдан авагч эсхүл түүний брокерын буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үнийн саналыг захиалгын санд буруу оруулсан нь тухайн үнээр хийгдсэн хэлцлийг цуцлах үндэслэл болохгүй.

Арилжаа зохион байгуулах

- 3.23. Бирж арилжааг ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд зохион байгуулна.
- 3.24. Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний гэрээг худалдагчаас ирүүлсэн доод үнээс эхлэн цахимаар үнэ хаялцуулан нээлттэйгээр арилжина.
- 3.25. Бирж нь худалдахаар зарласан нэг захиалгыг нэг худалдан авагчид худалдана.
- 3.26. Арилжаа нь дараах 3 үе шаттайгаар явагдана:
- 3.26.1. захиалга бүртгэх үе;
- 3.26.2. дуудах үе;
- 3.26.3. хэлцэл хийгдэх үе.
- 3.27. Биржийн арилжааны систем худалдан авах захиалгыг үнийн болон цаг хугацааны дарааллаар эрэмбэлнэ.
- 3.28. Худалдан авах захиалга бүртгэх үе нь **60** минутын хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед худалдан авах захиалгыг өөрчлөх, эсхүл цуцалж болно.
- 3.29. Худалдан авах захиалга бүртгэх үе дууссаны дараа дуудах үе нь 1 минут үргэлжлэх бөгөөд энэ үед шинээр захиалга оруулах, үнийг бууруулан захиалгад өөрчлөлт оруулах боломжгүй.
- 3.30. Дуудах үед худалдан авагч, эсхүл брокер нь өөрийн оруулсан үнийн саналыг өсгөж, шинэ үнэ оруулж болох бөгөөд үнэ шинэчлэгдсэн тохиолдолд бүрд дуудах үе 1 минутаас эхлэн тоологдоно.
- 3.31. Дуудах үеийн 1 минутын хугацаанд үнэ шинэчлэгдээгүй тохиолдолд хамгийн өндөр үнийн саналаар хэлцэл хийгдэнэ.
- 3.32. Энэхүү журмын 3.31-д заасны дагуу хэлцэл хийгдсэнээр тухайн арилжаа

дуусгавар болно.

- 3.33. Бирж нь арилжааг сэжигтэй гэж үзсэн тохиолдолд холбогдох журмын дагуу хяналт шалгалт хийж, шалгалтын тайланг Хороонд хүргүүлнэ.
- 3.34. Арилжааны гэрээний үүрэг хариуцлагыг тухайн арилжаанд зуучилсан брокер, брокергүй арилжаанд оролцож буй тохиолдолд худалдан авагч эсхүл худалдагч өөрөө бүрэн хариуцна.
- 3.35. Хэрэв худалдан авах санал гаргагч эсхүл түүний брокерийн буруутай үйлдэл нь тогтоогдвол тухайн буруутай этгээдийн арилжаанд оролцох эрхийг “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хяналт шалгалтын журам”-ын дагуу түдгэлзүүлнэ.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 4.1. Бирж нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан худалдан авах санал гаргагч, эсхүл брокерийн форвард гэрээний арилжаанд хязгаар тогтоох, дэнчинг нэмэгдүүлэхийг шаардаж болно.
- 4.2. Худалдан авах санал гаргагч, эсхүл брокер нь энэхүү журмын 4.1-д заасны дагуу арилжааны нэмэлт дэнчинг цаг тухайд нь байршуулаагүй, эсхүл бусад зөрчил гаргасан тохиолдолд Бирж нь тухайн худалдан авах санал гаргагч, эсхүл брокерийн арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО

Дэнчин, арилжааны шимтгэл

- 5.1. Худалдан авах санал гаргагч, эсхүл түүний брокер нь арилжаа эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө арилжааны дэнчинг Биржийн тусгай дансанд байршуулсан байна.
- 5.2. Зуучлагчгүйгээр арилжаанд оролцох тохиолдолд дэнчингийн хэмжээ нь спот арилжааны хувьд уул уурхайн бүтээгдэхүүний доод үнээр илэрхийлсэн захиалгын нийт үнийн дүнгийн 5-аас доошгүй хувь, форвард арилжааны хувьд 10-аас доошгүй хувьтай тэнцүү байна.
- 5.3. Зуучлагчтайгаар арилжаанд оролцох тохиолдолд дэнчингийн хэмжээ нь спот арилжааны хувьд уул уурхайн бүтээгдэхүүний доод үнээр илэрхийлсэн захиалгын нийт үнийн дүнгийн 5-аас доошгүй хувь, форвард арилжааны хувьд 5-аас доошгүй хувьтай тэнцүү байна.
- 5.4. Бирж нь дэнчингийн хэмжээг зах зээлийн эрсдэлийн нөхцөл байдлыг харгалзан тогтооно.
- 5.5. Дэнчинг шилжүүлэхдээ гүйлгээний утга хэсэгт компанийн оноосон нэр, арилжааны системд бүртгэгдсэн харилцагчийн код, дэнчингийн зориулалтыг тусгасан байна.
- 5.6. Тухайн арилжаанд худалдан авагчаар шалгарсан харилцагч нь энэхүү журмын Хавсралт 2-т заасан арилжааны шимтгэлийг нэхэмжлэх хүлээж авснаас хойш ажлын 3 өдрийн дотор төлнө.

- 5.7. Арилжаа явагдаагүй, худалдан авах санал гаргагч тухайн арилжаанд оролцоогүй, эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд арилжаа явагдаж дууссан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Бирж нь худалдан авах санал гаргагчид дэнчинг буцаан олгох бөгөөд банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр шилжүүлнэ.
- 5.8. Дэнчинг буцаахдаа худалдан авах санал гаргагчийн дэнчинг шилжүүлсэн дансанд, анх орж ирсэн валютаар буцаан шилжүүлнэ.
- 5.9. Худалдан авах санал гаргагчийн цахимаар ирүүлсэн албан ёсны (тухайн хуулийн этгээдийн төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг болон тамга тэмдэг дарсан албан тоот) хүсэлтээр дэнчинг дараагийн арилжаанд оролцох зорилгоор Биржийн дансанд хэвээр үлдээж болно.
- 5.10. Хэлцэл амжилттай хийгдсэн боловч худалдан авахаар шалгарсан харилцагч нь хэлцлийн төлбөрийг хугацаандаа, эсхүл бүрэн шилжүүлээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр худалдагчтай гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд Бирж нь дэнчингээс арилжааны шимтгэл хассан дүнгээр худалдагчид шилжүүлнэ.

Спот гэрээний төлбөр тооцоо

- 5.11. Худалдагч нь системд хийгдсэн хэлцлийн дагуу холбогдох хууль тогтоомж, Биржийн уул уурхайн бүтээгдэхүүний гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам болон бусад холбогдох журам, зааварт нийцсэн экспортын гэрээг худалдан авагчтай байгуулан хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор Биржид ирүүлнэ.
- 5.12. Энэхүү журмын 5.11-д заасан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 өдрийн дотор худалдан авагч нь гэрээний төлбөрийг 100% (дэнчинг хассан дүнгээр) худалдагчийн дансанд байршуулна.
- 5.13. Энэхүү журмын 5.12-т заасны дагуу гэрээний төлбөр төлөгдсөнөөс хойш ажлын 10 хоногийн дотор арилжаалагдсан бүтээгдэхүүнийг худалдагч талаас худалдан авагч талд хүлээлгэн өгч, актыг Биржид цахимаар ирүүлнэ.
- 5.14. Бирж нь акт, гэрээний төлбөрийг бүрэн төлсөн баримт (дэнчинг хассан дүнгээр) болон арилжааны шимтгэл төлсөн баримтыг үндэслэн ажлын 5 хоногийн дотор дэнчинг худалдагчийн нэрийн дансанд шилжүүлнэ.
- 5.15. Худалдагчийн төлбөрийн чадвар, бүтээгдэхүүний нөөц, борлуулалтын төлөвлөгөө болон бусад зүйлсийг харгалзан арилжааны гэрээний төлбөрийг Бирж нь эскроу дансанд байршуулж болно. Энэ тохиолдолд арилжигдсан бүтээгдэхүүнийг худалдагч бүрэн хүргэж дууссан тохиолдолд гэрээний төлбөрийг шилжүүлэх бөгөөд нарийвчилсан харилцааг Бирж болон худалдагчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

Форвард гэрээний төлбөр тооцоо

- 5.16. Худалдагч нь системд хийгдсэн хэлцлийн дагуу экспортын гэрээг Биржийн уул уурхайн бүтээгдэхүүний гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам болон энэхүү журам, эрх бүхий этгээдээс баталсан бусад журамд нийцүүлэн боловсруулж худалдан авагчтай байгуулна.

- 5.17. Энэ журмын 5.16-д заасан гэрээг системд хэлцэл хийгдсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор худалдан авагчтай байгуулж, Биржид ирүүлнэ.
- 5.18. Форвард гэрээний дагуу хүргэлт хийхээс ажлын 5 хоногийн өмнө худалдан авагч нь тухайн хүргэлтэнд ногдох төлбөрийг худалдагчийн дансанд шилжүүлэх ба хүргэлттэй холбоотой нарийвчилсан харилцааг экспортын гэрээнд заасны дагуу зохицуулна.
- 5.19. Худалдагч эсхүл брокер нь арилжаалагдсан бүтээгдэхүүнийг худалдагч талаас худалдан авагч талд хүлээлгэн өгснийг нотлох актыг Биржид ирүүлнэ.
- 5.20. Форвард гэрээний хугацаа дуусгавар болох үед Бирж нь гэрээний үүрэг бүрэн биелэгдсэн талаарх нотлох баримтыг үндэслэн ажлын 5 хоногийн дотор дэнчинг худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 5.21. Худалдагчийн төлбөрийн чадвар, бүтээгдэхүүний нөөц, борлуулалтын төлөвлөгөө болон бусад зүйлсийг харгалзан арилжааны гэрээний төлбөрийг Бирж нь эскроу дансанд байршуулж болно. Энэ тохиолдолд арилжигдсан бүтээгдэхүүнийг худалдагч бүрэн хүргэж дууссан тохиолдолд гэрээний төлбөрийг шилжүүлэх бөгөөд нарийвчилсан харилцааг Бирж болон худалдагчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

- 6.1. Бирж нь арилжааны болон ханшийн мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд арилжааны систем болон цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлнэ.
- 6.2. Арилжааны мэдээнд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:
 - 6.2.1. Арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр;
 - 6.2.2. Арилжаанд оролцсон нийт худалдан авах санал гаргагчдын тоо;
 - 6.2.3. Худалдагч хуулийн этгээдийн нэр, албан ёсны хаяг;
 - 6.2.4. Захиалгын бүртгэлийн дугаар;
 - 6.2.5. Доод үнэ;
 - 6.2.6. Хэлцэл хийгдсэн үнэ;
 - 6.2.7. Гэрээний нийт үнийн дүн;
 - 6.2.8. Гэрээний код;
 - 6.2.9. Үнийн өсөлтийн хувь;
 - 6.2.10. Арилжсан уул уурхайн бүтээгдэхүүний төрөл, ангилал, чанарын үзүүлэлт;
 - 6.2.11. Холбогдох хууль тогтоомж, журамд заасан бусад мэдээлэл.
- 6.3. Бирж нь арилжааны үнэ, хэмжээ, бүтээгдэхүүний төрөл, ангилал, худалдан авагчийн оршин байгаа улс, арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр зэрэг үзүүлэлтээр өдөр, долоо хоног, сар, жилээр тогтмол мэдээлнэ.
- 6.4. Бирж бүртгэлд байгаа форвард гэрээний талаарх дор дурдсан мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:
 - 6.4.1. Гэрээний нэр, код;
 - 6.4.2. Гэрээ дуусгавар болох хугацаа;
 - 6.4.3. Худалдагчийн зарласан доод үнэ;
 - 6.4.4. Төлбөр тооцоо хийх үнэ;
 - 6.4.5. Арилжааны хэмжээ;

- 6.4.6. Нийтэд хүргэх шаардлагатай бусад мэдээлэл.
- 6.5. Бирж, брокер, итгэмжлэгдсэн агуулах болон зах зээлийн бусад оролцогчид нь нийтэд зарлахаас бусад мэдээллийг задруулахыг хориглох бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу харилцагчийн мэдээллийн нууцыг чандлан хадгална.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Арилжаанд оролцогч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Бирж нь “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хяналт шалгалтын журам”-ын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
- 7.1.1. Сануулах;
 - 7.1.2. Арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах;
 - 7.1.3. Дэнчин хэлбэрээр байршуулсан хөрөнгийг гэрээний төлбөрт суутгах;
 - 7.1.4. Гишүүнээс хасах;
 - 7.1.5. Журамд заасан бусад арга хэмжээ;
- 7.2. Талуудын хооронд үүссэн маргааныг Биржийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлд хандаж шийдвэрлүүлнэ.
- 7.3. Худалдагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд зохих бүтээгдэхүүнийг нийлүүлэх цэгт бүрэн хүргээгүй тохиолдолд талуудын гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх цэгт хүргээгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1 %-тай тэнцэх алдангийг худалдан авагчид төлнө.
- 7.4. Худалдан авагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд худалдан авсан бүтээгдэхүүнээ бүтээгдэхүүн нийлүүлэх цэгээс бүрэн татан аваагүй бол талуудын гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1 %-тай тэнцэх хэмжээний алдангийг худалдагчид төлнө.
- 7.5. Энэ журмын 7.3, 7.4-д заасан хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг хамруулан үзнэ.
- 7.6. Бирж арилжаа, төлбөр тооцоотой холбоотой баримт материалд архивын нэгж үүсгэн 10-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.
- 7.7. Бирж нь энэхүү журамд нийцүүлэн нарийвчилсан журам, зааврыг батлан хэрэгжүүлж болно.
- 7.8. Арилжааны явцад Биржийн арилжааны системд доголдол үүсэх болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайн арилжаа зохион байгуулагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн арилжааг цуцалж, дахин зохион байгуулна.
- 7.9. Энэхүү журмын хэрэгжилтэд Биржийн хяналт шалгалтын алба, дотоод аудитын нэгж хяналт тавина.
- 7.10. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Биржийн бусад журмаар зохицуулна.
- 7.11. Энэхүү журмыг 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН АРИЛЖИХ ЗАХИАЛГА

Огноо:.....

Дугаар:.....

Улаанбаатар хот

Бид [уул уурхайн бүтээгдэхүүн худалдагч аж ахуйн нэгж, түүнийг төлөөлж]

энэхүү маягт, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд худалдан авах санал гаргагчид хүргэвэл зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн тусгасан болно.

1.Худалдагчийн мэдээлэл:

1.1 Оноосон нэр

1.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:

1.3 Регистрийн дугаар:

1.4 Үйл ажиллагааны чиглэл:

1.5 Оршин байх албан ёсны хаяг:
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/

1.6 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

1.7 Энэхүү маягттай холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:

1.8 Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүдийн товч мэдээлэл:

1.9 Төлбөр, тооцоог гүйцэтгэх банк,
дансны мэдээлэл:

1.10 Худалдан авагчид хүргэвэл зохих
нэмэлт мэдээлэл:

2.Арилжигдах бүтээгдэхүүний мэдээлэл:

2.1 Арилжигдах бүтээгдэхүүний
багцын тоо хэмжээ (тонн):

2.2 Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг:

2.3 Бүтээгдэхүүний төрөл, ангилал:

2.4 Бүтээгдэхүүний чанарын
үзүүлэлт: /Стандарт,
чанарын үзүүлэлтүүд/

2.5 Арилжаа зохион байгуулагдах
хугацаа:

2.6 Бүтээгдэхүүн хүргэж өгөх хугацаа:

2.7 Бүтээгдэхүүн татан авах хугацаа:

2.8 Дуудах доод үнэ, валютын төрөл:

2.9 Дуудах үед үнэ өсгөх хамгийн
бага дүн, нэгж (tick size):

2.10 Дэнчингийн хэмжээ:

2.11 Дэнчин байршуулах дансны
дугаар:

2.12 Чанарын шинжилгээ хийсэн
итгэмжлэгдсэн лабораторийн
мэдээлэл:
/нэр, хаяг, холбоо барих утас/

2.13 Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний товч дүгнэлт, чанарын үзүүлэлт:

**-Чанарын үзүүлэлтийн дээш доош өөрчлөгдөх хэлбэлзлийн хувь хэмжээг заана.*

Жишиг үзүүлэлт:	
Хэмжигдэхүүн	Чанарын үзүүлэлт /Өөрчлөлтийн хувь*
Үнслэг (хуурай, %)	
Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай, %)	
Хүхэр (хуурай, %)	
Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв, %)	
Г индекс	

/Бид энэхүү маягт болон түүнд хавсаргасан баримт, бичгийг төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээллэхийг зөвшөөрч байна/

Бүтээгдэхүүн арилжих захиалга хүргүүлсэн:

Овог, нэр:

Албан тушаал:

“.....”

ХХК-ийн

.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Захиалга хүлээн авсан ажилтны овог, нэр:	Захиалга хүлээн авсан огноо, цаг, минут:	Захиалга, түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэлийн ерөнхий нөхцөл

Шимтгэл төлөх этгээд	Зуучлагчгүй гэрээ	Зуучлагчтай гэрээ
Худалдагч тал	1 багц 100,000 төгрөг	
Худалдан авагч тал	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.1 хувь	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.08 хувь